



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭЭДЭЭ

№29
/473/

2023.02.09

Цаг үе, үйл явдал

ГАДААДЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ, ИХ ДЭЭД, СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин 2023 оныг "Залуу офицеруудын манлайлын жил" болгон зарласантай холбогдуулан ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн хэлтсээс Гадаадын цэргийн академи, сургууль төгсөгчдийн чуулга уулзалтыг анх удаа зохион байгууллаа.

Чуулга уулзалтаар гадаадын цэргийн академи, их, дээд сургуульд суралцсан бие бүрэлдэхүүн гадаад улс орнуудын цэргийн

сургалт бэлтгэлийн тогтолцоо, стандартын талаар хэлэлцэж, тэдгээрээс Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн сургалт, бэлтгэл, Батлан хамгаалах бодлогод нутагшуулах боломжтой зарим санал, бодлогыг боловсруулсан юм.

Мөн сургалтын төгсгөлд бие бүрэлдэхүүний дунд нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд үүнээс гарсан шийдэл, санаачилгыг БХЯ, ЗХЖШ-ын удирдлагуудад танилцуулахаар боллоо.

Батлан хамгаалах салбар, Монгол Улсын Зэвсэгт хүчний гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлэхийн хэрээр Монгол Улсаас гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад цэргийн мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон ахисан шатны сургалтуудад хамрагдаж буй алба хаагчдын тоо жил ирэх бүр нэмэгдсээр байгаа юм.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН АР ГЭРТ СЭТГЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол цэргийн нэгдсэн холбоо эмэгтэйчүүдийнхээ клубтэй хамтран Зэвсэгт хүчний 330 дугаар ангиас БНӨСУ-д НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нарын гэр бүлийн төлөөлөлд баяр хүргэж хүндэтгэл үзүүллээ.

Энэхүү арга хэмжээ нь Монгол Улсаа төлөөлөн гадаадад энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нартаа хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ тэдний гэр бүл үр хүүхдүүдэд аав ээжээрээ бахархах сэтгэл төрүүлэх,

урам өгч, дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Арга хэмжээнд МЦНХ-ны удирдлагууд, Эмэгтэйчүүдийн клубийн гишүүд, Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн удирдлага, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нарын гэр бүлийн төлөөллүүд оролцлоо.

Энэ үеэр БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж байгаа ахлах ахлагч Ц.Батболд, З.Бямба нар онлайн аар холбогдож үүргээ нэр төртэй сайн гүйцэтгэж байгаагаа ангийн захирагчдаа илтгэсний зэрэгцээ сэтгэлийн их дэм өгч ар гэр, үр хүүхдүүдэд нь

дэмжлэг тусалцаа үзүүлсэн МЦНХ-ны хамт олонд баярлаж буйгаа илэрхийлэн үүргээ сайн гүйцэтгээд эх орондоо эрүүл саруул очихдоо итгэл дүүрэн байгаагаа хэлсэн юм.

Мөн МЦНХ-ны ажлын албаны дарга бэлтгэл хурандаа Ж.Ванчинсүрэн офицер, ахлагч нарын ар гэрийн төлөөлөлд хандан "Дэлхийн энх тайвны төлөө хүчин зүтгэж буй энэ цагийн эгэл баатруудынхаа ар талыг найдвартай дааж үүргээ тайван гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангаж явдаг та бүгдээр бахархаж байна" гэсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,509	3,513
EUR	3,784	3,800
CNY	517	519
RUB	47.60	48.20
JPY	26.75	26.95
KRW	2.81	2.84

ЗУРХАЙ



2023.02.09 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

**ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН
ҮХЭР САР
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАР
НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.09-18.04

Барилдлага:

Төрөхүй

ШҮТЭН БАРИЛДАГА:

САНСАР

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйт сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 676,884,892

Эдгэрсэн

Нийт: 649,438,960

Нас барсан

Нийт: 6,776,393

Цахим шууданд

ДАЙНЫ ГЭРЧ БОЛСОН БААТРУУД 52-ХОН БОЛЖ ЦӨӨРӨВ



Ердөө саяхандаа, 2014-2015 онд ялалтын ойнууд тэмдэглэхэд дайн, байлдаанд оролцсон ахмад дайчдын тоо 400 хол давсан байв. Энэ тоо 2021 он гэхэд 100 гаруй болж буурсан бол 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 52 буюу ахархан хугацаанд тэн хагас нь бурхны оронд дэвшсэн байна. Энэ нь дайныг гэрчлэх баатрууд жилээр бус сар, өдрөөр цөөрөх гашуун үнэн бидэнтэй зэрэгцэн оршиж байгааг илтгэнэ.

Дайнд оролцогчдын Монголын хорооны бүртгэлээр Халхын голын байлдаанд оролцсон нэг, Чөлөөлөх дайнд оролцсон 31, Баруун хилийн зэвсэгт тулгаралтад оролцсон 20 ахмад дайчин эсэн мэнд байгаагаас хоёр нь эмэгтэй. Суман мөндөр, шуурган давшилтад тулалдаж явсан ахмад дайчдын хамгийн залуу нь 95-тай бол, хамгийн ахмад нь 102 настай. 1945 оны Чөлөөлөх дайнд Монгол Ардын Хувьсгалт Цэргийн 21 мянган цэрэг эрсийн нэг болж 20 гаруйхан насандаа буу агсан дайтаж явсан ахмад дайчин Ундрахын Доржпалам гуай өдгөө 102 настай.

Халхын голын байлдаанд оролцсон ахмад дайчдаас цор ганцаар түүхийн гэрч болж яваа буурал бол Дорнод

аймгийн Баяндунгийн уугуул 99 настай Ц.Чимэдцэрэн гуай. Тэрээр дайны жилүүдэд Баянтүмэний цэргийн эмнэлэгт сувилагч, индүүдэгч, тогооч хийж байсан бөгөөд тэгэхэд ердөө 15-хан настай байв.

Хоёр дахь эмэгтэй ахмад дайчин нь Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын уугуул, өдгөө 99 насны зооглож байгаа "Фронт" хэмээн хүндлэгдсэн С.Цэгмид. Аугаа их Эх орны дайны үед Монгол Улсаас ЗХУ-ын Улаан армид "Бүхнийг фронтод", "Бүхнийг ялалтын төлөө" уриа дор 8 удаагийн тусламжийн цувааг хүргэж өгсөн ба үүний нэгд нь төлөөлөгчдийн хамт 19 настай малчин бүсгүй явсан нь Сүрэнхорын Цэгмид байлаа. Түүнийг 2020 онд Батлан хамгаалах яамны шийдвэрээр байлдаанд оролцсон ахмад дайчнаар бүртгэж, мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар ОХУ-ын Төрийн дээд шагнал "Найрамдлын одон"-гоор шагнасан нь дайны голомтод тусламжийг цувааг хүргэсэн үйл хэргийг нь үнэлсэн, талархал илэрхийлсэн хэрэг юм.

Засгийн газраас ялалтын ойг арван жилийн үечлэлтэйгээр тэмдэглэж байх тухай шийдвэр гарсан нь цөөхөн үлдсэн ахмад дайчдын хувьд энэ нь тэр бүр үзээд

байх боломжгүй нөхцөл өнөөдрийн түвшинд байна. 95-102 хүртэлх настай буурал түүхийн гэрч болсон дайчдад тэгээр төгссөн ялалтын тэгш ой гэдэг дэндүү хол сонсогдож байгаа учраас Батлан хамгаалах яамны удирдлага тав болон тэгээр төгссөн ойн жилүүдэд тэмдэглэх санал оруулж, шийдвэрлүүлэн тэмдэглэж байсан билээ.

Энэ жил ч гэсэн баруун хилийн зэвсэгт тулгаралтын 75 жилийн ой тохиож байгаа бөгөөд ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Хил хамгаалах Ерөнхий газрынхан холбогдох шийдвэрийг нь гаргуулахаар ажиллаж байна.

Ер нь тэгээд түүхт ялалтын ойг тэмдэглэх нь улсынхаа тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүн ардынхаа амар амгалан байдлыг сахин хамгаалахын төлөө манай ахмад үеийнхэн яаж амь, бие хайрлалгүй тэмцэнийг залуу үедээ ойлгуулах, дайнд оролцогчид, ялалтад хувь нэмрээ оруулагчдын гавьяа зүтгэлийг мөнхөлж, дурсгалыг хүндэтгэхэд онцгой ач холбогдолтой. Дайн алсарсан ч халуун амь, бүлээн цусаараа эх орноо хамгаалж, ариун газар шороондоо шингэж мөнх

Гэрэл зураг-нэг агшин



Цохилох зүрх гэмээнэ
Цэцлэх сум гэмээнэ **ЭХ ОРНЫХОО ТӨЛӨВ**

нойрссон баатруудаа дурсаж, өдрөөс өдөрт цөөрч байгаа эх орны эрэлхэг хөвгүүд, охидоо алдаршуулах нь зүй ёсны хэрэг юм.

Ахмад дайчдын төлөөх үйл хэрэг бүхий байгууллага анх 1931 онд Цэргийн явдлын яамны сайд Г.Дэмидийн санаачилгаар Партизаны хэрэг эрхлэх комисс нэртэй байгуулагдаж, Г.Дэмид, Х.Чойбалсан, Д.Дашзэвэг, С.Янжмаа, Г.Бумцэнд, П.Тогтох нар тэргүүлж байжээ.

зорилгоор "Монголын ахмадын холбоо" олон нийтийн байгууллагыг байгуулахад дайн, байлдаанд оролцсон ахмад дайчдыг тусгайлан авч үзэж тус холбооны бүрэлдэхүүнд Дайнд оролцогчдын Монголын хороог байгуулсан түүхтэй. Дайнд оролцогчдын Монголын хороог Монголын ахмадын холбооны орлогч дарга хурандаа Г.Дашзэвэг, эрдэмтэн Л.Чулуунбат болон Д.Бямбацогт,



Тус комиссыг 1968 онд өргөжүүлж Хувьсгалт тэмцэлийн ахмад зүтгэлтний хороо болгосон бөгөөд хороог Ардын

Г.Дугарсүрэн, Ч.Самбуу нарын генералууд удирдаж байсан юм.

Ахмад дайчдын санал



хүсэлтийн дагуу тус хороо 2017 оноос Батлан хамгаалах яамны ивээлд үйл ажиллагаагаа явуулах болсон бөгөөд өдгөө тус хороог тэргүүлж байгаа бэлтгэл хурандаа Г.Лүндэнгийн хорооныхоо бүрэлдэхүүнийг цэргийн ажиллагаа, энхийг дэмжих үйлст оролцсон ахмад дайчдаар сэлбэн өргөжүүлж, Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын хороо болгон өөрчлөн зохион байгуулах саналыг Батлан хамгаалах,

Их Хурлын Тэргүүлэгчдийн нэгдүгээр орлогч дарга С.Лувсан, нэр нөлөө бүхий генералууд Ж.Цэнд-Аюуш, Б.Дорж, Ж.Жамьян нар тэргүүлж байв.

1988 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газрын санаачилгаар нийт ахмад настны нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн хамгааллыг сайжруулах

Зэвсэгт хүчний удирдлага дэмжсэн байна. Иймд тэрээр олон улсын цэргийн ажиллагаа, энхийг дэмжих ажиллагаанд оролцсон, удирдсан цэргийнхэнтэй хамтран өөрчлөн зохион байгуулахаар ажиллаж байгаа ажээ.

Ахмад Д.БОЛОР

Цахим шууданд

МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ ТУСЛАМЖИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГЧЭЭ



Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад эрэн хайх, аврах ажиллагаанд оролцох эмч, сувилагч, аврагчдын баг зорьсон газраа хүрсэн байна. Очсон даруйдаа багийн ахлагч ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал

Б.Ууганбаяр монголчуудын илгээсэн хүмүүнлэгийн тусламжийг гардуулан өгчээ. Эрэн хайх, аврах багийнхан сая Газинтэн хотоос 200 км зайд байрлах газар хөдлөлтийн голомт болох Хатай хот руу хөдөллөө.